## Хөрөвжсөн төл тэжээх аргаас



Хавар цас хайлж ус хомсдох болон бэлчээрийн өвс улам хатаж, шимт чанар нь бууран, малын сүү шим татарч төлөө цатгахгүй болдог. Энэ үед хөрөв төлийг сайн тэжээх хэрэгтэй. Хөрөв төл өвс, хүчит багсармал тэжээлд бүрэн орсон байх тул тэдгээрийг эхээс ялган хотонд үлдээж тэжээнэ.Төлд ногоон өвсийг дураар идүүлж байхын тулд өвсийг сараалжинд хийж байнга дүүргэж бай. Зун ургамал цэцэглэх үед хадаж бэлтгэсэн витаминт өвсөөр төл тэжээхэд хамгийн тохиромжтой. Бог малын төлд 100-150 гр, бод малын төлд 200-300 гр хүчит, багсармал тэжээл оногдохоор бодож нийт төлд өгөх тэжээлийг урьдчилан сайн дэвтээж бэлтгэнэ. Хивгийг чийглэж пургихгүй болгоод үд дундын алдад онгоцонд хийж байранд нь тавина. Эрдэс тэжээлийг онгоц буюу түмпэн саванд хийх, дүүжлэх замаар байнга долоолгож байна. Цэвэр бүлээн усаар өдөрт 1-2 удаа тогтмол услах буюу байранд нь үргэлж устай байлгаж дуртай цагтаа ууж байх боломжоор хангана. Хавар өдөр дулаан болж бэлчээрийн цас хайлсан үед хөрвө төлийг өдрийн цагт 3-4 цаг ойрын бэлчээрт бэлчээнэ. Ногоонд бүрэн цадтал нь ингэж тэжээж чадвал төлийг сэнсрэлтээс хамгаалж чадна.

Төв аймгийн Мал эмнэлгийн газар

Мал амьтны эрүүл мэндийн алба

Утас:- 7027-2361
Цахим хаяг: http://vet.to.gov.mn/

Төв аймгийн Мал эмнэлгийн газар

# ТӨЛД ТҮГЭЭМЭЛ ТОХИОЛДДОГ ЗАРИМ ӨВЧНИЙ ТУХАЙ



Мал амьтны эрүүл мэндийн алба

Утас: 7027-2361

# ТӨЛД ТҮГЭЭМЭЛ ТОХИОЛДДОГ ЗАРИМ ӨВЧНИЙ ШИНЖ ТЭМДЭГ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГААС



**ТӨЛИЙН БУЛЧИХ ЦАЙХ ӨВЧИН:** Булчин цайх нь малын бодис солилцооны хямралын улмаас булчингийн эд сөнөрөн их биеийн булчин, зүрхний хана цагаан цайвар өнгөтэй болж тэдгээрийн үйл ажиллагаа хямрах байдлаар илэрнэ.

**Мэдрэмтгий мал, амьтан:** Энэ өвчнөөр хурга, ишиг, тугал, ботго өвчилнө.

**Шалтгаан:** Эх малыг хээлтэй байхад, төллөсний дараах үед бие махбодид селен /Е витамин/ дутмаг байх үед төл мал энэ өвчнөөр өвчилдөг. Булчин цайх өвчин ихэвчлэн өвөл, хаврын улиралд нялх ба хөрвөөжсөн төлд ялангуяа 10-45 хоногийн хөрвөөжилттэй хурга, ишгэнд тохиолдоно.

**Шинж тэмдэг:** Өвчилсөн төлийн үс бүрзийн өнгөө алдах, биеийн ерөнхий байдал сул дорой болж нуруугаа хомбойлгон, толгойгоо унжуулан дөрвөн хөлөө алцайлган зогсох, Явахдаа бээцгнэж, бөгс нь гуйвах, Амнаас нь шингэн шүлс гарч, дуу нь сөөнгөтөн хөл дээрээ зогсож чадахгүй, элгээрээ мөлхөх, Хойд хоёр хөл нь бэрэвхийгээрээ нугарч хумслан гишгэх,бөгсөөрөө оцойн суух зэрэг шинж тэмдгүүд илэрнэ. Өвчилж эдгэрсэн төлийн өсөлт, хөгжилт саатан жижиг давжаа болох, улмаар үхэлд хүргэнэ.

**Оношлох:** Хурга ишгийг 80-100 см өндөрт өргөөд гэнэт буулгахад эрүүл хурга унахгүй дөрвөн хөл дээрээ буух ба харин өвчтэй бол унаад босож чадахгүй хэсэг зуур хэвтэнэ.



**Урьдчилан сэргийлэх арга хэмжээ:** Төлийг булчин цайх өвчнөөс урьдчилан сэргийлэхэд бэлчээрийг зөв ашиглах явдал юм.

Төлийн булчин цайх өвчин гардаг нутагт хээлтэй мал оторлуулахгүй байх

Булчин цайх гарсан айлыг эрт хаваржаанд гаргах, өвчин гардаггүй бэлчээрт шилжүүлэх

Хээлтэй малыг улаан буудай, хушуу будааны гуурсанд дагнан бэлчээхийг цээрлэх, удаж муудсан хивэг, сүрэл, үр тариагаар тэжээхгүй байх

Хэрэв бэлчээр нутгийг солих боломжгүй бол булчин цайх өвчин гардаг нутгийг бүх суурийн хээлтэй хонь ямааг төллөхөөс 20-30 хоногийн өмнө **селенлиг натрийн** бэлдмэлийг малын эмчийн заавраар арьсан дор тарина.



## НЯЛХ ТӨЛ ЧАЦГА АЛДАХ БУЮУ БИЖ ӨВЧИН:

Цаг уурын эрс тэрс нөхцөлтэй манай орны хувьд нялх төл чацга алдах тохиолдол элбэг байдаг.

**Мэдрэмтгий мал, амьтан:** Энэ өвчнөөр хурга, ишиг, тугал, ботго өвчилнө.

**Шалтгаан:** Нялх төлийг сүүнд нь хэт цаттах, дааруулах, муудсан хүйтэн дан сүүгээр угжих, дэлэн нь айсан эхийн сүү хөхүүлэх үед чацга алдана.

**Шинж тэмдэг:** Чацга алдсан төл хүндэрвэл эхээ хөхөхөө больж, эвгүй, өмхий үнэртэй чацгыг тасралтгүй гаргах, Шингэн их алдсанаас болж нүд ширгэж, бие суларч, хошуу, чих, мөч нь хөрч, шилээ татан унах шинж тэмдэгүүд илэрнэ.

**Урьдчилан сэргийлэх арга хэмжээ:** Чацга алдсан төлийг эхэд нь хөхүүлэхгүй сойж, 1-2 удаагийн хөхөх хугацаанд сулавтар давстай хар цай, хярмаар угжиж мойл, хад, гоёо, сөд, алтан гагнуур, төлөгч өвс, чихэр өвс, үхэр мэхээр, ганга, лидэр зэрэг эмт ургамлын хандны аль нэгийг уулгаж болно.

- * Цагаан будааны шүүс, өтгөн хар цайг ихээр уулгана.
- * Шар будааг хуурч, шатаагаад үнсийг нь зуурч өгнө.
- * Чацга тогтох хүртэл эхийн сүүг бага зэрэг хярамлан угжих хэрэгтэй
- * Биж өвчтэй төлийг элгэвч, нэмнээгээр дулаалж, дулаан чийггүй байранд байлгана.
- * Чацга тогтох үеэс бага багаар олон удаа эхэд нь хөхүүлнэ